



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/432

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 17 дугаар зүйлийн 17.1.10, Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, 4.1, Батлан хамгаалахын сайдын 2022 оны А/50 дугаар тушаал, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 24 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх, бие бялдрын болон ёс суртахуун, сэтгэл зүйн хүмүүжил олгох, эх орноо батлан хамгаалах бэлтгэл эзэмшүүлэх зорилгоор зохион байгуулагдсан Улсын аварга шалгаруулах Цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнд аймаг орон нутгаа төлөөлж, амжилттай оролцсон сурагчдад хүндэтгэл үзүүлсэн үйл ажиллагаанд 446,600 (дөрвөн зуун дөчин зургаан мянга зургаан зуу) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 446,600 (дөрвөн зуун дөчин зургаан мянга зургаан зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гарган зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА  Ш.ИДЭРБАЯСГАЛАН